

## 01\_Historical Overview of the Emergence of Inclusive Education

Тэгш хамруулах боловсрол үүсэж бий болсон түүхэн замнал

### #### Slide 1

This module traces the emergence and development of inclusion of students with disabilities in mainstream education.

Тус модуль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн боловсролд хэрхэн тэгш хамруулан сургаж эхэлсэн түүх болон одоогийн хөгжил ямар түвшинд буй талаар таниулах юм.

### #### Slide 2

In order to understand how the concept of inclusion of students with disabilities in education has evolved, an understanding of the historical perspectives informing the development of educational provision for students with disabilities and special needs is essential.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах болсон тухай болон энэ талаарх үндсэн ухагдахууныг авахын тулд тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дэмжиж буй боловсролын өнөөгийн бодлого, түүний хөгжил, түүхэн замналыг ойлгож судлах нь чухал юм.

### #### Slide 3

Throughout history, disabled people were largely treated as second-class citizens. Society excluded them and showed them little respect.

Түүхийн туршид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн 2 дахь давхаргын иргэд мэт үзэж, нийгэм бүхэлдээ тэднийг орхиж, үл ойшоох хандлагатай байсан байна.

### #### Slide 4

Disabled people tended to be regarded as inferior with few rights or privileges. Their disability has always been a serious impediment to their social and economic participation and integration.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн доод давхаргын хүмүүс мэтээр үзэж тэдний эрх хязгаарлагдмал байлаа. Тэдний хөгжлийн бэрхшээл нь нийгэм, эдийн засгийн харилцаанд ороход нь томоохон саад учруулдаг байлаа.

### #### Slide 5

Education for disabled students only emerged in the middle of the eighteenth century, prompted by the philosophy and principles of the European enlightenment informed by beliefs about the equality of all people and the human responsibility to care for others within society.

Анх 18-р зууны дунд үед Европыг соён гэгээрүүлэх үзэл баримтлал бий болж нийгэм дэх бүх давхаргын иргэдийг анхаарахад хүн бүр хариуцлагатай байх, бүх иргэдэд эрх тэгш хандах үзэл санааг нэвтрүүлсэний нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролын талаарх асуудал хөндөгдсөн байна.

### #### Slide 6

As a result, reform movements were established to address the inequalities experienced by marginalised groups within society, including disabled people and those deemed insane.

Энэхүү өөрчлөлт шинэчлэл нь нийгэмд гадуурхагдсан бүлэг болох солиотой, мангар хэмээн нэрлэгдэж байсан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөж байсныг ил тод болгосон юм.

#### #### Slide 7

For much of the twentieth century, it was common to segregate disabled people from the rest of society. Large numbers of disabled people were put away in institutions on the grounds that it was for their own good and the good of society.

20-р зууны ихэнх үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн бусад гишүүдээс тусгаарлах байдал зонхилж байсан. Өөрсдийнх нь болон нийгмийн сайн сайхны төлөө хийж буй үйлдэл гэсэн үндэслэлээр хөгжлийн бэрхшээлтэй олон тооны иргэдийг тусгайлсан газрууд руу илгээдэг байв.

#### #### Slide 8

However, the very existence of these institutions limited opportunities within wider society for disabled students. These institutions separated those who were disabled from their peers, who could continue with their schooling without any interference from disabled students.

Гэсэн хэдий ч эдгээр байгууллагууд оршин байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын нийгмийн өргөн хүрээний боломжийг хязгаарласан. Ийм төрлийн газрууд нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боломжийг хязгаарлахын зэрэгцээ тэднийг үе тэнгийн жирийн суралцагчдаас тусгаарлаж байв.

#### #### Slide 9

Innovative pedagogies were developed to support those who were deaf, blind, and intellectually disabled.

Хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй суралцагчдыг дэмжих шинэлэг арга зүй хөгжсөн.

#### #### Slide 10

Pioneering educators devised a variety of strategies to address the educational needs of disabled students, including sign language for the deaf, a raised print method for the blind and an appropriate pedagogy for those who were intellectually disabled.

Санаачлагч сурган хүмүүжүүлэгчид хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээнд нийцсэн янз бүрийн арга хэмжээг санаачилан хэрэгжүүлсэн. Үүнд, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж үсэг дүрс мэдрүүлэх хэвлэмэл материал, оюуны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тусгай арга зүй зэрэг багтах юм.

#### #### Slide 11

In the early twentieth century, general schooling became more organised. Compulsory attendance laws forced the state to make provision for disabled students, generally through special institutions and segregated classes.

20-р зууны эхэн үед ерөнхий боловсрол илүү зохион байгуулалттай болж эхэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг заавал сургах тухай хуулинд тусган ялангуяа тусгай сургалтын байгууллага, тусгай анги хэлбэрээр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд хамруулах болсон.

#### #### Slide 12

Parallel systems of regular and special education became established with different locations, specialised training for teachers in special education settings and the development of specialist provision, including therapeutic disciplines. Segregated educational provision remained largely unchallenged until the nineteen sixties.

Ердийн болон тусгай боловсрол нэгэн зэрэг тус тусдаа хөгжиж, тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх ажил, сэргээн заслын чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэх үйл ажиллагаа

хийгдэж байсан. 1960-аад он хүртэл энэхүү тусгаарлан боловсрол эзэмшүүлэх байдал олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр байсан.

#### Slide 13

In the nineteen sixties the civil rights movement in the United States and the normalisation movement in Scandinavia challenged the societal attitudes and approaches to disenfranchised and marginalised groups.

1960-аад онд болсон Америкийн иргэний эрхийн хөдөлгөөн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Скандинавийн хөдөлгөөн нь гадуурхагдан эрх нь зөрчигдөж буй бүлгүүдэд хандах нийгмийн харилцаа, хандлагыг өөрчлөх эхлэлийг тавьсан юм.

#### Slide 14

Disability groups followed minority ethnic groups that challenged the barriers preventing their full participation in society. This marked the beginning towards dismantling institutional segregated provision.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд угсаатны цөөнхийн бүлгүүдийн араас нийгмийн харилцаанд бүрэн хэмжээнд оролцоход нь тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаар уриалга гаргах болсон. Тэднийг нийгмээс тусгаарлаж буй байгууллагын тогтолцоог өөрчлөх эхлэлийг эдгээр хөдөлгөөнүүд тавьсан.

#### Slide 15

The second part of the twentieth century, was marked by efforts to establish more integrated special educational provision.

20-р зууны 2-р хагасд тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих илүү нэгдмэл цогц арга хэмжээ бий болсон байна.

#### Slide 16

According to normalisation principles, disabled people should be enabled to participate in mainstream society.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд жирийн иргэдийн адил амьдрах боломжийг бүрдүүлэх зарчмын дагуу тэд нийгмийн харилцаанд бусад жирийн хүмүүсийн адил оролцох боломжтой болсон.

#### Slide 17

The practice of segregated educational provision was challenged as it appeared to violate these normalisation principles. Education needed to be reoriented towards an integration framework designed to ensure that disabled students could participate to the greatest extent possible in their communities.

Тусгаарлан сургах тэрхүү арга хэмжээ нь жирийн иргэдийн адил амьдрах зарчимтай зөрчилдсөн тул асуудалтай тулгарсан. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг аль болох бусад жирийн иргэдтэй хамтран суралцах, харилцах боломжийг бүрдүүлсэн боловсролын цогц загварыг бий болгох шаардлага бий болсон юм.

#### Slide 18

The United States enacted legislation to respond to the serious issues raised by the civil rights movement and the critique of existing special educational provision.

Тухайн үед өрнөсөн хүний эрхийн хөдөлгөөнөөс дэвшүүлсэн асуудлууд болон тусгай хэрэгцээт боловсролын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд ирж буй шүүмжлэлүүдээс үүдэн Америкийн нэгдсэн улс хууль тогтоомж гарган мөрдөж эхэлсэн.

#### Slide 19

In nineteen seventy five, the Education for All Handicapped Children Act was passed to guarantee equal access to public education for children with disabilities.

1975 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд жирийн хүүхдүүдтэй хамт тэгш эрхтэйгээр сурах эрхийг хамгаалах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол”-ын хууль батлагдсан.

#### Slide 20

This federal law introduced the concept of the 'least restrictive environment', where their educational needs could be appropriately met. It marked a breakthrough in the shift away from segregated provision towards more integrated settings where disabled children and young people could be enabled to learn alongside their peers.

Тус хуулиар суралцахуйн орчинг хязгаарлагдмал бус харин суралцагчдын хэрэгцээнд нийцсэн байх ёстойг олон нийтэд таниулсан юм. Энэ хууль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, залуус, үе тэнгийхэнтэйгээ хамт суралцах боломжийг бүрдүүлж, тусгаарлагдан сурах системээс ангижрах томоохон өөрчлөлтийг авчирсан юм.

#### Slide 21

In the United Kingdom, the Warnock report of nineteen seventy eight provided a national review of special educational provision.

Англи улсад 1978 онд Ворнокийн тайланд тусгай хэрэгцээт боловсролын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх үндэсний мэдээллийг тусгасан байдаг.

#### Slide 22

The Warnock report challenged the traditional practice of identifying the child according to a category of handicaps and assigning the child to a special disability-specific school. It concluded that this approach to education for disabled children and young people was inappropriate.

Уг Ворнокийн илтгэлд хүүхдийг хөгжлийн бэрхшээлийн ангиллаар ялгаж, тусгай сургуульд сургадаг уламжлалт байдлыг буруутгасан байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг тухайн үеийн арга барилыг тохиромжгүй гэж үзсэн байна.

#### Slide 23

Identifying children according to disability categories often stigmatised them and provided limited relevant information about their actual educational needs. In fact, children with the same disability label were treated as a homogeneous group with broadly similar educational needs, yet in practice, these needs often varied widely.

Хүүхдийг хөгжлийн бэрхшээлийн ангиллаар ялгах нь тэдэнд сэтгэл гутралыг бий болгодог төдийгүй тэдний боловсролын хэрэгцээг тодорхойлох тал дээр дутмаг байдаг байна. Үнэн хэрэгтээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ижил төстэй боловсролын хэрэгцээтэй нэгэн төрлийн бүлэг гэж үздэг байсан ч бодит байдал дээр эдгээр хэрэгцээ нь ихэвчлэн ялгаатай байдаг.

#### Slide 24

The report challenged the practice of placing particular groups in society in special schools or classes for students learning difficulties instead of making the assessment of their special needs in education and provide them with adjustments in educational provision.

Мөн уг илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээг судалж тэдний хэрэгцээнд тохируулан дэмжих арга хэмжээ авахын оронд нийгэмд тусгай бүлэг үүсгэн, тусгаарлан сургаж буй байдлыг буруушаасан байна.

#### Slide 25

The report decided to replace the existing multiple categories of disability with the generic term 'special educational need'. This term applied to any pupil who required additional educational support, focussed on specific aspects of learning or **more generally across the majority of subjects.**

Тус илтгэлд одоо байгаа олон төрлийн хөгжлийн бэрхшээлийг "боловсролын тусгай хэрэгцээ" гэсэн ерөнхий нэр томъёогоор солих шийдвэр гаргасан бөгөөд уг нэр томъёо нь суралцахуйн тодорхой чиглэлээр эсвэл ихэнх хичээлээр дэмжлэг авах шаардлагатай хүүхэд бүрт хамааралтай.

####Slide26

The Warnock report marked a significant shift away from the traditional notions of educational difficulty as being primarily rooted and fixed within the individual student. Its concept of special educational need was more concerned with the interaction between the student and the learning contexts which the student experiences.

Ворнокын илтгэл нь боловсролын бэрхшээл бол суралцагчаас үүдэлтэй бөгөөд суралцагч бүр дээр засаж янзалж болдог гэсэн уламжлалт ойлголтоос их холдсон. Тусгай боловсролын хэрэгцээний үзэл баримтлал нь суралцагч ба суралцах нөхцөл байдал хоёрын хоорондын харилцан хамааралд илүү анхаарал хандуулсан.

#### Slide 27

It did not deny that within-student factors can have a significant impact on learning. Therefore, particular groups are likely to need to attend a special school at least for a period.

Энэ нь суралцагчаас шалтгаалах аливаа хүчин зүйлс тэдний сурлагад чухал нөлөө үзүүлдэг болохыг үгүйсгэж байгаа хэрэг биш юм. Тиймээс тодорхой нэг бүлэг суралцагчид тусгай сургуульд тодорхой хугацаанд хамрагдах шаардлага байж болно.

#### Slide 28

Some of them may, after intensive help in a special school, be able to continue their education in an ordinary school. Others may need to attend a special school for the whole of their school career.

Тэдний зарим нь тусгай сургуульд тодорхой хэмжээний тусламж, дэмжлэг авсаны дараа ердийн сургуульд үргэлжлүүлэн сурах чадвартай болж магадгүй юм. Харин зарим нь тусгай сургуульд үргэлжлүүлэн сурах шаардлагатай байж ч болзошгүй юм.

#### Slide 29

Enabling disabled students to participate fully in the educational system became a question of how committed governments were to develop more equitable systems of educational provision that valued diversity.

More equitable provision should reduce the marginalisation and stigmatisation experienced by disabled students and their families.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд бүрэн хамруулах болсон нь засгийн газрын өмнө боловсролыг бүх нийгэд тэгш хүртээмжтэй олгох боловсролын тогтолцоог хэрхэн бий болгох тухай асуултыг гаргаж тавьсан. Илүү тэгш байдлыг хангах нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид болон тэдний гэр бүлд тохиолдож буй гадуурхагдах, тусгаарлагдах явдлыг багасгах ёстой.

#### Slide 30

Provision in the United Kingdom spanned a continuum from greater levels to lesser forms of integration.

Англи улсад тэгш хамруулах боловсролыг дээд түвшнээс доод арга хэлбэр хүртэл үргэлжилсэн байдлаар хэрэгжүүлсэн.

#### Slide 31

Addressing the issue of equity for disabled students and their families would contribute to the development of more tolerant societies capable of responding appropriately to diversity.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид болон тэдний гэр бүлийн тэгш эрхийн талаарх асуудлыг хөндсөнөөр нийгмийн олон байдалд тохиромжтой хариу үйлдэл үзүүлж чадахуйц илүү тэвчээртэй нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

#### Slide 32

The Warnock committee identified three main types of integration: locational, social and functional.

Ворнокын хороо гурван гол хамруулах үйл ажиллагааг тодорхойлсон. Үүнд: байршлын, нийгмийн, үйл ажиллагааны.

#### Slide 33

Locational integration was characterised by the placement of disabled students within a mainstream setting, though often in a special unit or class with little interaction between disabled pupils and their same-age peers.

Байршлын хувьд хамруулах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй болон үе тэнгийн суралцагчидтай бага хэмжээгээр харилцах байдлаар суралцуулах явдал юм.

#### Slide 34

Social integration focused on enabling disabled students to interact socially with their same-age peers, though not necessarily in shared classrooms.

Нийгмийн хувьд хамруулах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг нийгмийн харилцаанд илүү оруулж, бусад үе тэнгийн хүүхдүүдтэй хамт анги танхим хамааралгүй чөлөөтэй харьцах боломжийг олгох юм.

#### Slide 35

Functional integration was epitomised by the participation of disabled students in mainstream classrooms alongside their same-age peers.

Үйл ажиллагааны хамруулалт нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн сургуульд үе тэнгийн суралцагчидтай хамтран суралцах боломжийг олгодог.

#### Slide 36

The legislation in the United States and the Warnock report marked significant turning points in the thinking around disability and special educational needs and the organisation and delivery of special educational provisions.

АНУ-ын хууль тогтоомж болон Ворнокын илтгэл нь хөгжлийн бэрхшээл болон тусгай хэрэгцээт боловсролын талаар дэлхий нийтээр санаа тавих, тусгай боловсролыг түгээх байгууллага болон арга барил зэрэгт чухал эргэлт хийсэн.

#### Slide 37

Disability was redefined. The medical Model sees the disabled person as the problem. It looks at what is 'wrong' with the student and not what the student needs. Under the medical model, students with disabilities should adapt themselves to fit into the educational environment around them.

Хөгжлийн бэрхшээл гэдэг нэр томъёо дахин тодорхойлогдсон. Анагаах ухааны үүднээс хөгжлийн бэрхшээл гэдэг бол өвчин, эмгэг юм. Энэ нь сурагчид юу хэрэгтэй байгаад биш харин сурагчийн юу нь "буруу" байгаад анхаарал хандуулдаг. Эмнэлгийн загвараар бол хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүрээлэн буй боловсролын орчиндоо дасан зохицох ёстой.

#### Slide 38

The social model of disability says that disability is caused by the way society is organised. It focuses on how the needs of students with disabilities can be met by society including schools and how to remove both physical and attitudinal barriers to the full participation of students with disabilities.

Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварт хөгжлийн бэрхшээл нь нийгмийн зохион байгуулалтаас үүдэлтэй гэж үздэг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээг сургууль, тэр дундаа нийгэм хэрхэн хангаж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бүрэн дүүрэн хамруулахад тулгарч буй бие махбодийн болон зан үйлийн саад бэрхшээлийг арилгахад чиглэдэг.

#### Slide 39

Unfortunately, the medical model does still prevail in education in many countries today and the social model is not universally applied. The educational environment disables students with disabilities by prejudices and by its failure to meet their needs created by disability and by denying their personal experience of disability.

Харамсалтай нь анагаах ухааны үүднээс тайлбарласан загвар өнөөдөр нилээд олон оронд зонхилон хэрэглэгдэж харин нийгмийн талаас тайлбарласан загвар дэлхий нийтэд төдийлөн хэрэглэгдэхгүй байна. Боловсролын орчинд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг гадуурхаж тэдний чадварыг үгүйсгэж, хэрэгцээг нь олж харахгүй, хувь хүний чадварыг нь үл ойшоож байна.

#### Slide 38

Instead, students with disabilities should be perceived as the **active agents** with full entitlements to their right to education who are capable of exercising autonomy over their educational *choices* and take control of their own education. This requires educational systems to facilitate the active participation of students with disabilities in educational decision-making.

Харин үүний оронд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид өөрийн боловсролд анхаарч, сонголт хийж, бие даан сурах чадвар бүхий сурах эрхээр бүрэн хангагдсан идэвхтэй суралцагч байх ёстой. Тиймээс шийдвэр гаргах чадвар бүхий, идэвхтэй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих боловсролын тогтолцоо өнөө үед шаардлагатай байна.

#### Slide 40

Students use the youtube video to analyse what happens when barriers are removed, and how the social model of disability helps disabled people to be independent and equal in society with choice and control over their own lives.

Суралцагчид youtube-ийн видео бичлэгийг ашиглан саад бэрхшээлийг арилгахад юу болдог, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд бие даасан, эрх тэгш байх, өөрсдийн амьдралаа сонгох, хянахад хэрхэн тусалдаг талаар дүн шинжилгээ хийнэ.

#### Slide 41

Developing integrated educational provision involved all participants and stakeholders in education. Increased funding was made available, legislation was enacted and parents became more active participants in the decision-making processes around the education of their children.

Боловсролын цогц арга хэмжээг хөгжүүлсэн нь боловсролын бүхий л оролцогч талуудыг хамруулсан. Үүний зэрэгцээ аливаа арга хэмжээг санхүүжүүлэх боломжууд нээлттэй болж, хууль тогтоомжууд хэрэгжиж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын эцэг эх шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох болсон.

#### Slide 42

Policy options regarding integration vary across countries, and three broad policy options in integration practices can now be identified: separate, flexible, and responsive systems of provision.

Улс бүр тэгш хамруулах төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа бөгөөд туршлагаас харахад 3 том бодлого тодорхойлогдоод байна. Үүнд: хэрэгжилтийн тусгаарласан, уян хатан, хариу үйлдэл бүхий тогтолцоонууд байна.

#### Slide 43

'Two-track' integration policies were evident in the Netherlands, Belgium and Germany, where the two parallel school systems existed and worked independently of each other.

Нидерланд, Бельги болон Герман улсуудад “2-зам” хэмээх тэгш хамруулах бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь сургуулийн хоёр зэрэгцээ тогтолцоо орших бөгөөд нэгнээсээ үл хамааран бие даан ажиллаж байсан.

#### Slide 44

Denmark, England and Wales and the United States, followed 'multi-track' policies where a flexible system of educational provision was devised, and a continuum of services was made available to disabled students.

Дани, Англи, Вэйлс, АНУ зэрэг улсууд “олон зам” хэмээх боловсролд хамруулах уян хатан тогтолцоо бүхий бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тасралтгүй суралцах боломжийг олгож байна.

#### Slide 45

In countries such as Italy and Sweden, a 'one-track' integration policy operated where disabled students were educated in mainstream schools alongside their same age peers to the greatest possible extent.

Зарим улсууд тухайлбал Итали болон Швед улсад “нэг зам” бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ердийн сургуульд үе тэнгийн хүүхдүүдтэй хамтран суралцах боломжийг олгодог байсан.

#### Slide 46

By the nineteen nineties, progress towards inclusion appeared to be stalling. Integrated provision tended to be conceptualised in placement terms rather than considering the support infrastructure required to deliver effective inclusive educational provision for disabled students.

1990-ээд оны үед тэгш хамруулах боловсролын талаарх авах арга хэмжээ удааширсан. Цогц арга хэмжээ ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг боловсролд үр дүнтэй тэгш хамруулахад нэн шаардлагатай байсан хөрөнгө мөнгийг шийдвэрлэхээс илүүтэйгээр дэд бүтцийн асуудал дээр төвлөрсөөр байлаа.

#### Slide 47



Whereas the belief that learning difficulties arose from individual student deficits resulted in an emphasis on separate educational provision, flexible and responsive systems of provision became associated with the belief that learning difficulties are caused by a combination of individual and environmental factors.

Суралцахуйн бэрхшээл нь сурагчдын хувийн хомсдлоос үүдэлтэй гэсэн итгэл үнэмшил нь тусгаарлах боловсролын үйлчилгээг чухалчилж байсан бол сургалтын уян хатан, хариуцлагатай тогтолцоо нь суралцахуйн бэрхшээл нь хувь хүн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн хослолоос үүдэлтэй гэсэн итгэл үнэмшилтэй холбоотой болсон.

#### Slide 48

With the Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD), the focus shifted to the structural, social, political and cultural shortcomings in society being significant barriers to the inclusion and full participation and development of persons with disabilities. The Convention recognises the right to inclusive education for all persons with disabilities.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн конвенцэд нийгмийн бүтэц зохион байгуулалт, олон нийтийн үйл ажиллагаа, улс төрийн болон соёлын үйл ажиллагатай холбоотой хөрөнгө мөнгөний гачигдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо, тэднийг боловсролд тэгш хамруулах зэрэг асуудалд томоохон саад тогтор учруулж байна хэмээн дурджээ. Мөн уг конвенцэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд боловсролд тэгш хамрагдах эрхтэй хэмээн тусгажээ.

#### Slide 49

To conclude:

The concept of educational inclusion has now been firmly established within policy and legislation in many countries throughout the world.

Дүгнэж хэлэхэд, өнөө үед дэлхийн олон оронд тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт бодлогын баримт бичгүүдэд тусгагдаж, энэ талаарх хууль тогтоомжууд хэрэгжиж эхлээд байна.

#### Slide 50

However, it is equally evident that there are many contrasting - and, in some cases -, conflicting interpretations of how educational inclusion should be implemented in practice.

Гэсэн хэдий ч тэгш эрхтэй байх асуудал олон талын эсэргүүцэлтэй нүүр тулж байгаа бөгөөд зарим тохиолдолд бодит амьдрал дээр хэрэгжиж буй тэгш хамруулах боловсролын талаарх үзэл бодлууд, тайлбарууд хоорондоо зөрчилдсөөр байна.

#### Slide 51

As noted by the Grand Chamber in the case of Roma students in the Czech Republic, we should not underestimate the enduring strength and influence of traditional conceptualisations of special education that continue to exert a hold over current procedures through the emphasis on defining educational needs according to traditional categories of disability and allocating resources on this basis.

Чех улсад суралцаж байсан Ромын суралцагчдын хэрэгт Дээд шүүхээс тэмдэглэснээр, Хөгжлийн бэрхшээлийн уламжлалт ангиллын дагуу боловсролын хэрэгцээг тодорхойлох, үүний үндсэн дээр нөөцийг хуваарилах замаар одоогийн журамд нөлөөлсөөр байгаа тусгай хэрэгцээт боловсролын уламжлалт үзэл баримтлалын хүч чадал, нөлөөг бид дутуу үнэлж болохгүй гэжээ.

#### Slide 52

In addition, the increasing marketisation of education with accompanying competition between schools for status and resources can produce a hostile environment quite unsympathetic to the inclusion agenda.

Нэмж хэлэхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд таатай орчин бүрдүүлэх, сургалтын нөөц бий болгох болон сургуулийн нэр хүндийг өсгөх зэрэг зах зээлийн өрсөлдөөн бий болж байгаа нь нэг талдаа тэгш хамруулах боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд таагүй байдал үүсгэж байна.

#### Slide 53

To realize inclusive education, support should be provided to teachers and school personnel in developing appropriate responses to any student experiencing difficulties in school ...

Тэгш хамруулах боловсролыг дэмжихийн тулд тухайн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад илүү хүрч ажиллаж, хичээл зааж буй багш нарыг илүү дэмжих нь зүйтэй юм.

#### Slide 54

... and to challenge exclusionary procedures within schools and the education system. A human rights approach to educational inclusion demands that exclusionary practices at all levels within the education system are challenged.

Мөн сургууль болон боловсролын тогтолцоонд гарч буй гадуурхах үйлдлийг таслан зогсоох хэрэгтэй. Боловсролд тэгш хамрагдах хүний эрхийн тухай заалтад бүх шатны сургалтын тогтолцоонд гарч буй гадуурхалтыг таслан зогсоох ёстой гэсэн байдаг.

#### Slide 55

Achieving educational inclusion is a process that challenges societies at a fundamental level to demonstrate who is really valued within society and how the human rights of all students can be realised within education systems.

Тэгш хамруулах боловсролд амжилттай хүрэх нь нийгмийн суурь түвшинд нийгэмд хэн үнэ цэнэтэй гэдгийг, мөн бүх шатны боловсролд нийт суралцагчдын хүний эрх хэрхэн хэрэгжиж байгааг харуулах үйл явц юм.